



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№42 /256/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.03.02

Цаг үе, үйл явдал

НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЦЭРГИЙН ШТАБЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН ХОЁР ШАТНЫ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штабын бие бүрэлдэхүүнд онол, практикийн хоёр шатны сургалтыг зохион байгууллаа.

Практикийн сургалтаар бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, спортын үр чадварыг дээшлүүлэх, хамт олны чөлөөт цагийг зөв зохиистой, үр бүтээлтэй өнгөрүүлж,

хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн арга хэмжээг бүх нийтийн хүртээл болгох, хөгжүүлэх зорилгоор нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын

Цэргийн штабын офицер, ахлагч нарын дунд спорт тэмцээнийг 2 дугаар сарын 24-ний өдөр Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн спорт зааланд зохион байгуулав.

Онолын сургалтын хүрээнд хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Цэргийн бүртгэл, цэрэг татлагын үед хөтөлгөх баримт бичгийн бүрдүүлэлт" сэдэвт сургалтыг 2 дугаар сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Сургалтаар цэргийн бүртгэл болон цэрэг татлагын үед хөтөлгөх баримт бичгийн бүрдүүлэлт, зохион байгуулж явуулах аргачлал болон гадаадын орнуудад цэргийн бүртгэл, татлагыг зохион байгуулдаг арга туршлага, сургаж зэрэг сэдвүүдээр лекц орлоо. Сургалтын төгсгөлд нийт бие бүрэлдэхүүнээс хууль эрх зүйн сорил авч сургалтаас гарсан санал хүсэлтийг нэгтгэн дээд шатны байгууллагад уламжлах юм. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас 2022 онд зохион байгуулагдах сургалтуудад тавигдах илтгэлүүдийг нэгтгэн гарын авлага болгох юм.

НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-1	-20

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
33	26

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,880.00	2,888.0
EUR	3,225.0	3,245.0
CNY	455.00	456.00
RUB	32.00	36.50
JPY	24.95	25.10
KRW	2.40	2.41

ЗУРХАЙ



2022.03.02 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 30/

ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХӨХ БАР ӨДӨР

Үс ЗАСУУЛБАЛ:

Эрлэг лугаа учирна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 07.32-18.37

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Суудал: Төмөр

Энэ өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, сүм дуганыг сэргээх, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, бомбын үйл, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохиистой.

Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ "ХАТАН ИЖИЙ" НАРЫГ ШАЛГАРУУЛЖ, ӨРГӨМЖЛӨЛ ХҮРТЭЭВ



Зэвсэгт хүчний Жанжин штаб, Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Зэвсэгт хүчний "Хатан ижий" шалгаруулах ёслолын ажиллагаа өнөөдөр боллоо. БХЯ-ны 111, Зэвсэгт хүчний 101 жилийн ой, "Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг угтаж зохион байгуулсан энэхүү ёслолын ажиллагаанд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг, Суртал хүмүүжил, мэдээлэл, сэтгэл зүйн хэлтсийн дарга хурандаа Ц.Батсайхан, Хэвлэл мэдээллийн албаны дарга хурандаа Б.Отгонбаяр, ЦДБЭЧ-ын дарга хурандаа Г.Золзаая болон Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний жил бүрийн "Хатан ижий" нар, энэ жил өргөмжлөлийн эзэнээр шалгарсан алдарт эхчүүд, тэдний гэр бүл, үр хүүхэд, ач, зээ нар оролцлоо.

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд олон жил хүчин зүтгэж, олон хүүхэд төрүүлж өсгөсөн, үр хүүхдүүд

нь удам дамжин төрийн цэргийн байгууллагад ажилладаг ээжүүдийг тодорхой шалгуур үзүүлэлтээр тодруулдаг уламжлалтай бөгөөд энэ нь гэр бүл, үр хүүхдүүд, мөрдөстэй алба хаагчдаараа бахархах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зэрэг томоохон ач холбогдолтой юм. Өнөө жилийн "Хатан ижий" өргөмжлөлийн эзэнээр ЗХЖШ-ын Ахмадын хорооноос нэр дэвшүүлсэн Б.Загдсүрэн, ҮБХИС-аас нэр дэвшүүлсэн Ц.Алтанцэцэг, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлээс нэр дэвшүүлсэн Г.Оюунчимэг, Зэвсэгт хүчний 011 дүгээр ангиас нэр дэвшүүлсэн Л.Цэдээ, Зэвсэгт хүчний 089 дүгээр ангиас нэр дэвшүүлсэн Д.Алтанцэцэг, Зэвсэгт хүчний 234 дүгээр ангиас нэр дэвшүүлсэн Б.Отгон, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангиас нэр дэвшүүлсэн Н.Халиун, Батлан хамгаалахын төв архиваас нэр дэвшүүлсэн Д.Цэнд, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангиас нэр дэвшүүлсэн С.Нэргүй нар шалгарсан юм.

АГААРЫН ЦЭРГИЙНХЭН ГАВЬЯАТДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэрэг, Цэргийн нисэх хүчний шалган-нисгэгчээр ажиллаж байсан байлдааны сөнөөгч онгоцны анхны I цэргийн нисгэгч, багш нисгэгч, чөлөөнд байгаа дэд хурандаа С.Шаравсамбууд цэргийн нисэх хүчинд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар энэ оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын гавьяат нисгэгч гэх хүндтэй цолыг олгосон билээ.

Тэгвэл өчигдөр Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын удирдлага, хамт олон гавьяат нисгэгчээ хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Энэ үеэр чөлөөнд байгаа дэд хурандаа С.Шаравсамбуу "Би Ардын Армид сөнөөгч онгоцны нисгэгчээр 20 шахам жил тасралтгүй алба хаасан. Сүүлд Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэрэгт нисэх хүчний шалган-нисгэгч албан тушаалд ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан. Энэ хугацаанд Монголын тэнгэрт 1526 цаг 33 минутын 2717 удаагийн нислэгийг үйлджээ. Монгол Улсын гавьяат нисгэгч гэх энэ эрхэм цол бол орчин үеийн цэргийн нисэх хүчний сөнөөгч онгоцны нисгэгчдээс анхных нь болж байна. XX зууны сүүл үед надтай хамт ажиллаж байсан Цэргийн нисэх хүчний нийт нисгэгчид, инженер техникийн бие бүрэлдэхүүн, хангалт үйлчилгээний, холбооны тусгай батальоны нийт бие бүрэлдэхүүний хөдөлмөр зүтгэлийг өндрөөр үнэлж надад энэ шагналыг хүртээсэн гэж ойлгож байна" хэмээгээд Зэвсэгт хүчинд алба хааж байгаа нийт бие бүрэлдэхүүнд ажлын амжилтыг хүсэн ерөөлөө.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,271,626 /69.8%/	2,172,986 /66.8%/	1,024,186 31,5%
		104,101 /3,2%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭЛРСЭН
8318 +112	110	8089

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 438,876,739

Эдгэрсэн

Нийт: 371,058,520


Нас барсан

Нийт: 5,984,046



Цахим шууданд

НЭГТГЭЛ, АНГИУДЫН ПОЛИГОНЫ ДАДЛАГА ЯВАГДАЖ БАЙНА



тогтооно. Энэ сургуулийн жилд байлдааны нэгтгэл, анги, салбаруудаас гадна төрөл мэргэжлийн бүх анги, салбарууд үндсэн үүргийнхээ хүрээнд явуулж буй тусгай тактикийн хээрийн сургуулийнхаа сэдэв, зохион байгуулалттай уялдуулан байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг төлөвлөн явуулж, үүрэг гүйцэтгэх чадавхаа дээшлүүлж байгаагаараа онцлог юм.

Мөн нэгтгэл, ангиудын хээрийн гаралтын бэлтгэл, явц байдал, зарим салбаруудын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуультай Батлан хамгаалахын сайдын тушаалаар томилогдсон БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалын хамтарсан ажлын хэсгүүд танилцаж, шалган туслах ажлыг зохион байгуулж байна. Нэгтгэл, анги, салбаруудын хөгжүүлэх шатны сургалт 4 дүгээр сараас эхэлнэ.

СБЗХ-ийн мэргэжилтэн дэд хурандаа А.БАТСҮХ

Зэвсэгт хүчний 2021-2022 оны сургуулийн жилийн нэгдүгээр үе төгсөх шатандаа орж нэгтгэл, анги, салбарууд хээрийн гаралт /полигоны дадлага-аа зохион байгуулж, үндсэн салбаруудынхаа жигдрэлтийг хангаж байна. Хээрийн гаралтын

төгсгөлд нэгтгэл, ангиуд байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль болон тусгай тактикийн хээрийн сургуулийг зохион байгуулан явуулж, үндсэн салбаруудынхаа үүрэг гүйцэтгэх чадавх, бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшнээ

ГАДААД ХЭЛНИЙ ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГ ЭХЭЛЛЭЭ



хаагчдын гадаад хэлний мэдлэг, сургалтын үр дүнг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох зорилгоор явуулж байна.

Орос, англи хэлний түвшин тогтоох нэгдүгээр шатны үзлэгийг 2 дугаар сард цахимаар явуулсан бол Франц, герман, турк, хятад, солонгос хэлний түвшнийг ҮБХИС-ийн материаллаг баазыг түшиглэн 2 дугаар улиралд зохион байгуулна.

Орос, англи хэлний түвшин тогтоох хоёрдугаар шатны үзлэгийг нэгдүгээр шатанд 70-аас дээш оноо авсан буюу "ахисан дунд шат"-ны мэдлэгтэй алба хаагчидтай бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, унших, сонсох, ярих, бичих гэсэн үнэлгээгээр ур чадварыг нь шалгаж үнэлнэ.

Үзлэгт Зэвсэгт хүчний болон гадаад хэлний бусад дамжаанд албан ёсоор суралцан төгсөж, гэрчилгээ /сертификат/ эзэмшсэн, түүнчлэн гадаадад иргэний болон цэргийн их, дээд сургууль, академи төгссөн алба хаагчид хамрагдана.

Хэрэв гадаад хэлний бие дааж сурсан бол хэлний төвүүдээр түвшнээ албан ёсоор тогтоолгож, баталгаажуулсны үндсэн дээр үзлэгт хамрагдаж болно.

СБЗХ-ийн мэргэжилтэн ахмад Д.БААСАНДОРЖ

БАЙЛДААНЫ БУУДЛАГЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу хоногийн хээрийн сургуулийг 2 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Мөн салааны байлдааны буудлагыг "Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын салаа маневрын хориглолт" сэдвээр байлдааны буудлагатай хээрийн сургуулийг амжилттай явууллаа. Салааны байлдааны буудлагаар Мотобуудлагын салааг 82 мм-ийн миномётын, зенитийн 23 мм-ийн

ЗУ-23, СПГ-9 тоотууд болон мэргэн буудагчийн бүлэг (мотоциклтой), гранатомётчины бүлэг (мотоциклтой) морьт цэргүүд оролцуулсан нь онцлог байлаа. Тус сургууль нь офицер, ахлагч, цэргийн гэрээт албаны түрүүч нарын ур чадвар, бие бялдар, тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэл, байлдааны зэвсэглэл, техникүүдтэй харьцах дадлагыг дээшлүүлсэн сургалт боллоо.

Дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД

"БИД НЭГ ГЭР БҮЛ" УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн удирдлага, ахлагчийн зөвлөлөөс 2 дугаар сарын 26-ны өдөр ангийн ахлагч нарын ар гэрийн төлөөлөлтэй "Бид нэг гэр бүл" уулзалтыг зохион байгуулав. Энэ үеэр ангийн ахлагч сургагч ахлагч Х.Түвшинжаргал "Ахлагчийн албаны өнөөгийн байдал, сахилга харууцлагыг нэмэгдүүлэх нь" сэдвээр яриа таниулга хийсэн юм.

Мөн барилга, инженерийн цэргийн онцлог, ахлагч нарын нийгмийн хамгааллыг дээшлүүлэх, ажлын цаг ашиглалтыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, санхүүгийн мэдлэг олгох зэрэг олон сэдвээр сургалт явуулсны зэрэгцээ ахлагч нарын ар гэрт тулгамдаж буй асуудлын талаар харилцан ярилцаж, ар гэрийн бүрэлдэхүүний санаа сэтгэгдлийг сонслоо.



МӨНГӨН ТУСЛАМЖИЙГ ГАРДУУЛАН ӨГЛӨӨ

Өнгөрсөн оны 12 дугаар сарын 26-ны өдөр "Сонсголон" цэргийн хотхоны Цэргийн цагдаагийн тасгийн дарга ахмад Г.Эрдэнэбатын гэр цахилгааны гэмтлийн улмаас шатаж томоохон хохирол амссан учраас тэрээр өнөөдөр гэр бүлийн хамт найзынхаа зуслангийн байшинд түр амьдарч байна.

Түүний гэр бүлд тус дэм болох үүднээс ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтэс, Зэвсэгт хүчний 011, 013, 017, 150 дугаар анги болон Цэргийн цагдаагийн нийт бие бүрэлдэхүүн тодорхой хэмжээний мөнгөн тусламжийг үзүүлжээ.

Харин БНӨСУ-д НҮБ-ын энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй XI ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүн



ахмад Г.Эрдэнэбатын гэр бүлд зориулсан хандивын аяныг зохион байгуулж тодорхой хэмжээний мөнгөн хандив цуглуулсныг ЗХЖШ-

ын Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Т.Буянбат өчигдөр гардуулан өглөө.

30-КМ"-ИЙН ЯВГАН МАРШААР ...



Зэвсэгт хүчний 232 дугаар анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг дээшлүүлэх, сэтгэл зүйн болон бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг нэмэгдүүлэх алба, салбаруудын харилцан ажиллагааг хангах зорилгоор бие бүрэлдэхүүнийг 3 бүлэгт хуваан "Тактик, тусгай бэлтгэлийн цогцолбор" 30-км-ийн явган маршийг ангийн байнгын байрлал-"Духан", "Цэргийн овоо",

"Нэргүй өндөрлөг", "Тосон нуур" гэсэн маршрутаар зохион байгууллаа.

Явган маршийн явцад хичээлийг 4 цэгээр буюу "Духан" буудлагын талбайд "СБД-1" боловсруулах, "Байр зүйн баримжаалал хийх аргачлал, холбооны бэлтгэл Р-105 радио станцыг ажилд бэлтгэх", "Тактикийн норматив 1, 2, 3", "Хордсон газар орныг туулах, химийн зэвсэгээс хамгаалах 1, 2, 3а, 3б норматив боловсруулах" хичээлүүдийг зохион байгууллаа.

Ахмад Ц.ОТГОНСҮРЭН

Зэвсэгт хүчний 303 дугаар анги

ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭР ...

Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдсан "Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр", "Тогтвортой эрх чөлөө" олон улсын ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн "Нисдэг тэрэгний техник, засвар үйлчилгээний бүлгүүдийн туршлага, сургаж" сэдэвт хэлэлцүүлэг ангийн байрлалд зохион байгуулагдлаа.


Хэлэлцүүлэгт ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, газрын даргын орлогч хурандаа Д.Дугаррагчаа, Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн дэд хурандаа Н.Цогтгэрэл, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын захиргаа удирдлагын хэлтсийн



дарга хурандаа Б.Баярсайхан, ангийн удирдлагууд болон үүрэг гүйцэтгэсэн 8 ээлжийн удирдлага, бие бүрэлдэхүүн оролцож ажиллагааны өмнөх бэлтгэлийн онцлог, үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүний судалгаа, ар тал, техникийн хангалтын байдал, сэтгэл зүйн бэлтгэлжилт,

ажиллагааны газар оронд тулгарч байсан хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулсан туршлага, сургаж, ажиллагааны онцлогийг харуулсан ном, гэрэл зургийн цомог, алдрын танхимд дурсгалын буланг нээх зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлгийг өрнүүлэв.

"ХИМИЙН ӨДӨР"-ИЙН ХҮРЭЭНД ...



Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө, "Цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулж явуулах тухай" ангийн захирагчийн тушаал, долоо хоногийн товч, цагийн хуваарийн дагуу офицер, ахлагч нарын химийн бэлтгэлийн дадлага, ур чадварыг нэмэгдүүлэх дадлагыг зохион байгуулав.

Ахмад Б.НАРАНБААТАР